

III. ОЛОН УЛСЫН ЭДИЙН ЗАСГИЙН ХАРИЛЦАА

ДЭЛХИЙН ЭДИЙН ЗАСАГ ДАХЬ ИНТЕГРАЦИЙН ҮЙЛ ЯВЦ

*МУИС, ОУХС-ийн дэд профессор,
доктор (Ph.D) С.Отгонбаатар*

Өнөө үед дэлхийн эдийн засгийн нэгдмэл системийг бүрдүүлж байгаа глобаль үйл явцын зэрэгцээ улс орнууд газар зүйн ойр дөт байдалдаа түшиглэн хамтын сонирхлоо нэгтгэж, худалдааг дэмжих зорилгоор бие биендээ хөнгөлөлттэй нөхцөл олгох хэлбэрээр нэгдэн нийлж байгаа бүс нутгийн хандлагууд өргөжиж тухайн орнуудын хөгжлийн ирээдүйг улам бүр тодорхойлох болов.

Дэлхийн улс орнуудын аж ахуйн үйл ажиллагаа улам ихээр харилцан хамааралтай болж хамтын ажиллагаа нь өргөжин тэлэхийн зэрэгцээ аж ахуйг хөтлөх бүтэц, зохион байгуулалтын шинэ шинэ хэлбэрийг үүсгэх болсон нь эдийн засгийн интеграцийн үйл явцыг ихээхэн эрчимжүүлж байна.

1950-аад оны үед Баруун Европын орнуудад бий болсон аж үйлдвэрлэлийн өсөлт, нийгмийн томоохон өөрчлөлтүүд нь үйлдвэрлэл, капиталыг нэгтгэх процессыг өргөжүүлж, олон улсын хөдөлмөрийн хуваарийг улам гүнзгийрүүлэхэд нөлөөлсөн бөгөөд интеграцийн үйл явц нь энэ үеэс эдийн засгийн хөгжлийн бодит зүй тогтол болж эхэлсэн гэж үздэг.

Тухайн үеийн неолиберал чиглэлийн эдийн засагчид (А. Мюллер-Армак, А. Предол, Б. Репке болон бусад) "интеграц" гэдэг ухагдахууныг онолын хувьд үндэслэсэн гэж тооцогддог бөгөөд тэд хэд хэдэн орны хүрээнд зах зээлийн хүчин чөлөөтэй үйлчилж байх зах зээлийн нэгдсэн орон зай байгуулах явдлыг интеграц гэж тодорхойлсон байна. Үүнээс үүдэн интеграц гэсэн нэр томъёог тайлбарласан хэд хэдэн чиглэл гарчээ. Үүнд чөлөөт худалдааны зарчмын үндсэн дээр интеграцид орж буй орнууд нэгдэн нийлэх явдал гол чухал юм гэж үзсэн зах зээлийн буюу неолиберал чиглэл, зах зээлийн үйл явцад төрөөс оролцох явдал зайлшгүй чухлыг үндэслэсэн дирижист чиглэл, интеграцийн үйл явц дахь зах зээлийн ба төрийн зохицуулалтын хоорондох харилцан буулт (компромисс)-ыг олох гэж оролдсон зах зээлийн институционал чиглэл зэргийг дурдаж болох юм¹.

Орчин үеийн эдийн засгийн интеграцийн тод жишээнд Европын Холбоо, НАФТА, АНД-н бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагаа зэрэг нь зүй ёсоор тооцогддог.

¹ Зүүн Хойд Азийн эдийн засгийн хамтын ажиллагаа 1995он. УБ.48 дахь тал

Европын Холбоо

2002 оны 1-р сараас Европын холбооны 12 орон нэгдсэн мөнгөн тэмдэгтэд шилжсэнээр Баруун Европын интеграц орчин үеийн интеграцийн хамгийн боловсронгуй хэлбэр болохоо нотлов. 1951 онд Европын нүүрс-гангийн нэгдэл байгуулагдаж Франц, Баруун Герман, Итали, Бельги, Нидерланд, Люксембург зэрэг орнууд нэгдэн орсон нь Европын интеграцийн эхлэл болж улмаар 1957 онд Европын Эдийн засгийн хамтын нийгэмлэг, 1993 онд Европын холбоо болж өргөжсөн түүхтэй. Эдүгээ Европын Холбоонд дэлхийн экспортын 57%, импортын 55% ноогдож байгаа ба эгнээндээ 15 орныг нэгтгэсэн дэлхийн томоохон үйлдвэрлэгч, хэрэглэгчдийн томоохон зах зээл болоод байна².

Умард Америкийн Чөлөөт Худалдааны Бүс (НАФТА)

НАФТА нь 1994 оны 1-р сарын 1-ээс Канад, АНУ, Мексикийн хооронд байгуулагдсан гэрээний (1992 онд гарын үсэг зурсан) үндсэн дээр үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн юм. Уг гэрээнд Умард Америкт аж ахуйн үйл ажиллагааг илүү чөлөөтэй болгох үүднээс дараахи нөхцлүүд тусгагдсан байна. Үүнд: гишүүн орнууд нэгдсэн зах зээлд чөлөөтэй нэвтрэх, хөрөнгө оруулалт хийх, үйлчилгээ явуулах, оюуны өмчийг хамгаалах, ажил хэргийн хүмүүсийг түр хугацаагаар чөлөөтэй нэвтрүүлэх, нэгдсэн стандартыг дагаж мөрдөх, маргааныг зохицуулах гэх мэт. Үүнээс гадна гэрээ хэлэлцээрийн дагуу 15 жилийн дотор хөрөнгө оруулалтыг чөлөөтэй болгох, гаалийн татварыг чөлөөлөх, энэ хугацаанд дээрх 3 орны хоорондын худалдааны бүх саадыг арилгахаар төлөвлөсөн байна³.

Ази-Номхон Далайн бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагаа

Ази-Номхон далайн бүс нутаг эдийн засгийн өсөлтөөр өнөөдөр бусад бүс нутгийг давамгайлж байна. Энэ бүс нутагт дэлхийн үйлдвэрлэлийн 60 орчим хувь, гадаад худалдааны нийт эргэлтийн 40 хувь ноогдох боллоо. Хэрвээ 1970-аад оны үед Ази-Номхон далайн орнуудын гадаад худалдаа Европ болон дэлхийн бусад бүс нутгийн орнуудад үндсэндээ чиглэгдэж байсан бол сүүлийн жилүүдэд бүс дотроо өөр хоорондоо хийх худалдаанд давуутай шилжих болов.

Ази-Номхон далайн бүс нутгийн ихэнх орны дотоодын нийт бүтээгдхүүний өсөлт жилд 5-6%, гадаад худалдааны эргэлт 9-11% болж байгаа нь дэлхийн дунджаас хавьгүй давж байна. Шинээр үйлдвэржсэн

² The unification of Europe harmonizing technical regulations CBI, Netherlands 1994, page 16

В. П. Колесова, М. Н. Осьмева, Мировая экономика, Москва 2000, стр 36

³ И. Н. Герчикова, Международные экономические организации, Москва 2001 стр 275

болон Зүүн Өмнөд Азийн орнуудын хувьд эдгээр үзүүлэлтүүд бүр ч илүү (ДНБ өсөлтийн хурдац 7%, гадаад худалдааны өсөлт 11%) байгаа юм. Эдгээр орнууд дэлхийд хамгийн тогтвортой хөгжиж буй улс орнуудад зүй ёсоор тооцогдох болсон байна. Ази-Номхон далайн орнуудын эдийн засгийн хөгжлийн энэ их давшингүй өсөлтийг бүс нутгийн орнуудын харилцан хамаарал бүхий хамтын ажиллагаа эрчимжсэний үр дүн гэж үздэг.

Ази-Номхон далайн бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагаанд өнөөдөртөө бүс нутгийн орнуудын хоёр талын хамтын ажиллагаа зонхилж байгаа ч бүс нутгийн зарим хэсэгт ялангуяа Зүүн Өмнөд Азийн хил залгаа орнуудад эдийн засгийн интеграцийн хамгийн энгийн хэлбэр болох худалдааны чөлөөт бүсүүд байгуулагдан бие биендээ хөнгөлттэй нөхцөл олгож худалдааг дэмжих нэгдсэн бодлого явуулах болсон нь олон талт хамтын ажиллагааны эхлэл болох төдийгүй тухайн орнуудын гадаад худалдааны эргэлтийг сайжруулж хөгжилд нь зохих түлхэц өгч байна.

Бүс нутгийн эдийн засгийн харилцааны онцлогийн тухай авч үзэхийн тулд эдгээр орны эдийн засгийн түргэн өсөлт төдийгүй, үндэстэн хоорондын харилцаанд нөлөөлөх бусад талыг харгалзан үзэх нь чухал юм. Ази - Номхон далайн бүс нутгийн бүрэлдэхүүнд хөгжилтэй орнууд: Австрали, Канад, Япон, Шинэ Зеланд, АНУ, Ази дахь шинээр үйлдвэржсэн орнууд (Гонконг, Солонгос, Тайван, Сингапур), ЗӨАН-ийн орнууд (Бруней, Индонез, Филиппин, Малайз, Сингапур, Тайланд), Арлын улсууд, (Фиджи, Франц, Полинез, Папуа Шинэ Гвиней, Соломоновын арлууд, Вануату, Баруун Самоали), Латин Америкийн орнууд (Чили, Колумб, Кост-Рика, Эквадор, Салвадор, Гватемал, Гондурас, Мексик, Никарагуа, Панам, Перу) болон Орос, Хятад улс орж байна.

Ази-Номхон далайн бүс нутгийн интеграцийн үйл явцыг зангидах нэгдсэн механизм бий болгох талаар бүсийн орнууд нилээд идэвхтэй ажиллаж байгаагаас гадна олон улсын төрөлжсөн байгууллага болох НҮБ-ын Ази-Номхон далайн орнуудын эдийн засаг, нийгмийн комисс, Азийн хөгжлийн банк, мөн засгийн газрын бус байгууллага болох Номхон далайн орнуудын эдийн засгийн хамтын ажиллагааны зөвлөл болон Номхон далайн орнуудын эдийн засгийн зөвлөл чухал үүрэг гүйцэтгэж байгаа билээ. Ийнхүү дэлхийн эдийн засаг дахь интеграцийн үйл явц бүс нутаг бүрт харилцан адилгүй өрнөж байгаа ч хөгжлийн шатанд тавигдаж байгаа зорилт, хэрэгжүүлэх арга зам нь нийтлэг шинжтэй юм.

Дэлхийн эдийн засгийн интеграц нь хөгжлийнхөө өнөөгийн түвшинд хүртэл дөрвөн үе шат дамжсан гэж үздэг. Үүнд:

I үе шат. Интеграцид оролцогч орнууд гаалийн тарифыг хөнгөлж, худалдааны болон бусад хязгаарлалтыг багасгаж худалдааны чөлөөт бүс байгуулах зэргээр хамтран ажиллаж эхэлсэн. Энэ үед интеграцид улс орнууд өөр хоорондын худалдаанд тавьдаг хориг саадыг тэглэж, харин бусад оронтой харилцах харилцааны хувьд асуудлыг бие даан шийдвэрлэх болов.

II үе шат. Гаалийн холбоо байгуулж худалдаа, ажиллах хүч болон капиталын урсгалд нэгдсэн тариф тогтоосон. Энэ үед зөвхөн өөр хоорондын худалдааны хориг саадыг арилгаад зогсоогүй, гуравдагч орны хувьд баримтлах худалдаа, гаалийн нэгдсэн бодлогоо тодорхойлж, нэгдсэн сүлжээг бий болгосон. Үүнд Европын эдийн засгийн нийгэмлэг, одоогийн Европын холбооны практик үйл ажиллагааг дурьдаж болох юм.

III үе шат. Эдийн засгийн интеграцийн хөгжлийн бодитой үе шат нь эдийн засгийн нэгдмэл холбоог үүсгэн байгуулах явдал байдаг. Энэ үе шатанд интеграцид орсон орнууд өөрсдийн нутгаар бараа таваарыг нэвтрүүлэхээс үйлдвэрлэх хүчний хөгжлийн гол хүчин зүйл болох капитал буюу ажиллах хүчний шилжилтийг илүүтэйд үзэх болсон байна.

IV үе шат. Интеграцийн үйл явцыг эдийн засгийн нэгдмэл бодлого, нэгдсэн валютын үндсэн дээр хөтлөн жолоодох болсон. Интеграцийн энэхүү үе шатанд хөгжил нь улс төр, эдийн засгийн холбооны хүрээнд илүү үр өгөөжтэй явагдаж байна. Улс орнууд эдийн засгийн бодлогоо уялдуулахын зэрэгцээ түүнийг зохицуулах арга хэлбэр, механизмыг ойртуулах, адилтгах ажил эрчимжиж байна. Үүний сацуу бүс нутгийн орнууд гадаад улс төрийн бодлогоо зохицуулж ирсэн нь тэдгээрийн хүч, хөрөнгийг зохистой ашиглахад ач тус өгч байна.

Интеграцийн хөгжлийн дээрх үеллээс үзэхэд хамтын ажиллагаа нь улс хоорондын хүрээнээс бүс нутгийн түвшинд улам бүр шилжиж, хамтран шийдвэрлэх асуудлын цар хүрээ өргөжин тэлж байгаа нь илт байна. Энэ нь дэлхийн улс орнуудын хөгжлийн нийтлэг чиг хандлага, глобалчлалын үйл явцтай уялдахын зэрэгцээ шинжлэх ухаан-техникийн дэвшил, үйлдвэрлэх хүчний хөгжил, хүрээлэн буй орчинг хамгаалах асуудлуудын зохистой шийдлээс урган гарч байгаа юм.

Эдийн засгийн интеграцийг үүсгэж байгаа процессыг схемчлэн авч үзвэл дараахи байдлаар томъёологдоно⁴.

Үйлдвэрлэх хүчний хөгжил


Олон улсын хөдөлмөрийн хуваарь

• Үйлдвэрлэл, капиталын олон улсын нэгдмэл шинж

Эдийн засгийн интеграц

Үүний зэрэгцээ эдийн засгийн интеграци нь өөр хоорондоо харилцан нягт уялдан холбогдсон зах зээлүүдийн нэгдэл гэж үзэж болох юм. Дэлхийн эдийн засгийн интеграцийн хөгжлийн явцад барааны, капиталын, ажиллах хүчний, үйлчилгээний гэсэн дөрвөн харилцан уялдаа бүхий зах зээл тогтнож тэдгээр нь дэлхийн нэгдмэл зах зээлийг бүрэлдүүлж байна.

⁴ В. П. Колесова, М. Н. Осьмева, Мировая экономика, Москва 2000, стр 62



Эдийн засгийн интеграци нь тухайн бүс нутагт хамтын ажиллагааны үр ашигтай хэлбэрийг хөгжүүлэх өргөн боломж олгож улмаар худалдааг өргөжүүлэх, үйлдвэрлэлийн хоршилт, дагналтыг гүнзгийрүүлэхэд түлхэц өгөхөөс гадна капитал, хүч нөөцийг нэгтгэж аж ахуйн шинэ шинэ хэлбэр, бүтэц зохион байгуулалтыг үүсгэж байна. Тухайлбал үйлдвэрлэл, банк, санхүүгийн томоохон нэгдлүүд болох Үндэстэн дамнасан корпораци (ҮДК), Үндэстэн дундын банк (ҮДБ), Санхүү, аж үйлдвэрийн бүлэглэл (САҮБ) зэргийг нэрлэж болно.

Орчин үеийн интеграцийн боловсронгуй хэлбэр болох аж ахуйн бүтэц, зохион байгуулалтын эдгээр хэлбэрүүд нь олон улсын аж ахуйн үйл ажиллагааны нийтгэлийн тодорхой нөхцөл байдалд үүсч байна. Үүнд:

Нэгд, үйлдвэрлэлийн дагналт, хоршилт гүнзгийрснээр капиталын бөөгнөрөл бий болсон бөгөөд улмаар энэ нь үндэсний хүрээнээс хальж чөлөөтэй хөрвөх түвшинд хүрч, үйлдвэрлэлийн олон улсын үйл ажиллагааны нийтгэлийн дээд хэлбэр гэж хэлж болох үндэстэн дамнасан корпораци (ҮДК) үүсэх нөхцөл нь болж байна.

Хоёрт, банкны капиталын бөөгнөрөл нь Үндэстэн дундын банкны (ҮДБ) концернийг төрүүлэх болов.

Гуравт, Санхүү-аж үйлдвэрийн бүлэглэлүүдийн нэгэнт буй болсон сүлжилд түшиглэсэн санхүүгийн капиталын үндэстэн дундын бүлэглэлүүд болох САҮБ үүсч эхлэв.

Дөрөвт, Бүс нутгийн улс орнуудын хамтын ажиллагаа, өөр хоорондын интеграци нь дэлхийн улс орнуудын эдийн засгийн бодлогыг улам илүү уялдуулах, зохицуулах түвшинд хүргэж байна.

Дэлхийн эдийн засаг дахь эдийн засгийн интеграци нь дараахи түвшинд явагдаж байна⁵.

⁵ А. К. Шуркалина, Н. С. Цыпин, Мировая экономика, Москва 2000, стр 242-244

Бүс нутгийн эдийн засгийн интеграци

Интеграцийн түвшин (тавигдсан зорилго)	Нэр, байгуулагдсан он	Гишүүн орнууд
1	2	3
Худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны хэлэлцээр	Европын холбоо, хуучин ЗХУ-ын Бүгд найрамдах улсуудтай хамтран ажиллах түншлэлийн хэлэлцээр (<i>Cooperation and Partnership Agreements, 1994</i>)	Европын холбоо, Белорус, Казахстан, ОХУ, Украин
	Европын холбоо, Дорнод Европын улсуудын хамтын ажиллагааны хэлэлцээр (<i>EU Association Agreements</i>), 1991-1995	Болгар, Чех, БНУУ, Польш, Румын, Словак, Эстон, Латви, Литва, Словен
	Америкийн аж үйлдвэрлэгчдийн холбоо (<i>Enterprise for the American Initiative-EAI</i>), 1990	АНУ, Латин-Америкийн улсууд бараг бүхэлдээ
Чөлөөт худалдааны бүс	Европын чөлөөт худалдааны нийгэмлэг (<i>European Free Trade Association -EFTA</i>), 1960	Австри, Исланд, Лихтенштейн, Норвеги, Финланд, Швед
	Европын эдийн засгийн бүс (<i>European Economic Area-EEA</i>), 1994	Европын холбооны улсууд, Исланд, Лихтенштейн
	Балтийн чөлөөт худалдаа-ны бүс (<i>Baltic FTA</i>), 1993	Эстон, Латви, Литва
	Төв Европын чөлөөт худалдааны бүс (<i>Central European FTA</i>), 1992	Чех, БНУУ, Польш, Словак
	Умард Америкийн чөлөөт худалдааны хэлэлцээр (<i>North American Free Trade Agreement-NAFTA</i>), 1994	Канад, Мексик, АНУ
	Зүүн өмнөд Азийн чөлөөт худалдааны хэлэлцээр (<i>ASEAN Free Trade Agreement-AFTA</i>), 1992	Бруней, Индонез, Малайз, Сингапур, Тайланд, Филиппин
	Австрали, Шинэ Зеландын эдийн засаг хамтын ажиллагааг өргөжүүлэх худалдааны хэлэлцээр (<i>Australia-New Zealand Closer economic relations Trade Agreement-ANZCERTA</i>), 1983	Австрали, Шинэ Зеланд

	Ази-Номхон далайн бүс нутгийн хамтын ажиллагаа (<i>Asian Pacific Economic Coopeartion-APEC</i>), 1989	Австрали, Бруней, Гонконг, Канад, Хятад, Кирибати, Малайз, Маршалын арлууд, Мексик, Шинэ Зеланд, Папуа-Шинэ Гвиней, БНСУ, ОХУ, Сингапур, АНУ, Тайланд, Тайвань, Филиппин, Чили
	Бангкогийн хэлэлцээр (<i>Bangkog Agreement</i> , 1993)	Бангладеш, Энэтхэг, БНСУ, Лаос, Шри Ланка
Гаалийн холбоо	Европын холбоо, Туркийн хамтын ажиллагааны хэлэлцээр (<i>Turkey association Agreement-EU</i>), 1963	Европын холбоо, Турк
	Арабын нэгдсэн зах зээл (<i>Arab Common Market-AM</i>), 1964	Египет, Ирак, Иордани, Ливи, Мавритан, Сири, Йемен
	Төв Америкийн нэгдсэн зах зээл (<i>Central American Common Market CACM</i>), 1961	Коста-Рика, Сальвадор, Гватемалл, Гондурас, Никарагуа
	Колумби, Эквадор, Венесуэлийн чөлөөт худалдааны бүс (<i>Colombia, Ecuador, Venezuela FTA</i>), 1992	Колумби, Эквадор, Венесуэл
	Дорнод Карибын улсуудын байгууллага (<i>Organization of East Carribean States</i>), 1991	Антигуа Барбуда, Доминик, Гренада, Монтсеррат, Сент-Китс ба Невис, Сент-Люсси, Сент-Винсент ба Гренада
Нэгдсэн зах зээл	Персийн булан Арабын орнуудын хамтын ажиллагааны зөвлөл (<i>The Gulf Cooperation Council</i>), 1981	Бахрейн, Кувейт, Оман, Катар, Саудын Араб ОАЭ
	Андын нэгдсэн зах зээл (<i>Andean Common Market, Andean Pact</i>), 1990	Болив, Колумби, Эквадор, Перу, Венесуэл
	Латин-Америкийн интеграцийн холбоо (<i>Latin American Integration Association-LAIA</i>), 1960	Аргентин, Болив, Бразил, Чили, Колумби, Эквадор, Мексик, Перу, Уругвай, Венесуэл
	Өмнөд Конусын нэгдсэн Меркосурин зах зээл (<i>Southern Cone Common Market-Mercosur</i>), 1991	Аргентин, Бразил, Парагвай, Урагвай
	Карибийн нийгэмлэг ба нэгдсэн зах зээл (<i>Carribean Community and Common Market-CARICOM</i>), 1973	Антигуа Барбуда, Багамын арлууд, Барбадос, Белиз, Доминика, Гренада, Гайана, Ямайка, Монтсеррат, Сент-Китс Невис, Сент-Люсси, Сент-Вин-сент Гренадины Тринидад Тобаго

Эдийн засгийн холбоо	Европын эдийн засгийн хамтын нийгэмлэг (<i>European Economic Communities-ЕЭС</i>), 1957, одоогоор Европын холбоо (<i>European Union-EU</i>), 1993	Австри, Бельги, ИБУИНВУ, Дани, Герман, Греци, Ирланд, Испани, Итали, Люксембург, Нидерланд, Португали, Финланд, Франц, Швед
	Бенилюксийн орнуудын эдийн засгийн холбоо (<i>Belgium, Netherlands, Luxemburg economic union-BENILUX</i>), 1948	Бельги, Нидерланд, Люксембург
	Тусгаар улсуудын хамтын нөхөрлөл (<i>Commonwealth of Independent States</i>), 1992	Армен, Азербайджан, Беларусь, Гүрж, Казахстан, Киргиз, Молдав, ОХУ, Таджикистан, Туркменистан, Украин, Узбекистан
	Арабын Магрибын холбоо (<i>Arab Maghreb Union</i>), 1989	Алжир, Ливи, Мавритан, Марокко, Тунис
	Хөрш орнуудын чуулга (<i>CrossBorder Initiative</i>), 1993	Бурунди, Коморын арлууд, Кени, Мадагаскар, Малави, Мавритани, Намиби, Руанда, Сейшелийн арлууд, Танзани, Уганда, Замби, Зимбабве
	Лагосын төлөвлөгөө (<i>Lagos Plan of action</i>), 1973	Сахараас өмнөд орших Африкийн бүх улсууд
	Ману голын холбоо (<i>Manu River Union</i>), 1973	Гвиней, Либер, Сьера-Леоне
	Баруун Африкийн эдийн засаг, валютын холбоо (<i>West African economic and Monetary Union</i>), 1994	Бенин, Буркина-Фасо, Кот-д'Ивуар, Мали, Нигер, Сенегал, Того

Integration process, its role in the world economic system, origins and forms it is undertaking is highlighted. Emphasize is given to a new process of integration in regional and global scale suited to a new environment.